

**“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2021 оны 04 дүгээр сарын
26-ны өдөр

№ ХЭХ 03/01

Улаанбаатар
хот

**“Жуулчин Дюти фрий” ХК-ийн 2021 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
тэмдэглэл.**

2021 оны 04 сарын 26-ны өдөр 10:00 минут, Даваа гараг, Хан-Уул дүүргийн 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Таван Богд Группийн төв байрны, 2,5 дугаар давхрын хурлын танхимд хуралдав.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Сайн байцгаана уу. Хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн амар амгаланг эрье. Улс орон даяар МУ-ын засгийн газрын тогтоол гарч бүх нийтийн бэлэн байдлын зэргийг 2021 оны 04 дүгээр сарын 09-ны өдрөөс 25-ны өдөр хүртэл хугацаанд тогтоосон бол 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр МУ-ын Засгийн газар дээрх хугацааг 2021 оны 05 дугаар сарын 08-ны өдрийг хүртэл сунгаж шийдвэрлэсэн. Иймд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн, хөл хориотой хүнд нөхцөлд хуралд оролцох боломжгүй байгаа хувьцаа эзэмшигч нарыг ZOOM.US ашиглан хуралд оролцох боломжоор нь хангаж ажилласан болохыг хуралд оролцож буй хувьцаа эзэмшигч нартаа дуулгаж байна. Ингээд хурлын дэгийг та бүхэнд танилцуулъя.

Хурлын дэгийг танилцуулав.

Одоо хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу хурлын ирц бүртгэлийн талаар тооллогын комиссын дарга Т.Солонго танилцуулна.

Тооллогын комиссын дарга Т.Солонго: Сайн байцгаана уу. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн танилцуулъя.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит энэ хуралд 3 хувьцаа эзэмшигч оролцож, нийт саналын эрх бүхий нийт хувьцааны 76,92 хувь болж байгааг хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигч нар болон хурлын даргад мэдээлсүгэй. Ингэснээр хурлыг хүчин төгөлдөрт тооцож хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг үргэлжлүүлэхэд ирц хүрсэн байна.

Хурлын ирцийн тогтоолыг танилцуулав.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Хурлын ирц хүчин төгөлдөр болсон байна. Тооллогын комиссоос тогтоол гарсантай та бүхэн танилцлаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар ТУЗ-ийн гишүүн Ч.Ванчин-Эрдэнийг томилсон боловч Хурлын дарга Бүх нийтийн бэлэн зэрэгт шилжсэнтэй холбоотой хуралд оролцох хурлыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Отгонбаяр даргалуулахаар ТУЗ-ийн дарга шийдсэн байна.

Хурлын дэгийн дагуу компанийн үйл ажиллагааг танилцуулаад хурлаа эхэлье.

Хурлын дарга Ц.Отгонбаяр: Сайн байцгаана уу та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. 2020 оны үйл ажиллагааны тайланг танилцуулъя. Асууж тодруулах зүйл байвал шууд шууд асуугаад явах боломжтой.

Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах /Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Отгонбаяр/ танилцуулав.

Компанийн эрхэм зорилго бол зах зээлд чанарын шаардлага хангасан өндөр чанартай үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж салбартаа манлайлах гэсэн зорилготой. МУ-ын хэмжээнд нийт 18-н татваргүй барааны дэлгүүр үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнээс Буянт Ухаа Олон Улсын Нисэх Буудалд дийлэнх буюу 10-н дэлгүүр ирэх явах урсгал дээр ажиллаж байна. Сар бүр бараа материалын татан авалтын судалгаа хийдэг юм. Бараа татан авалтын үзүүлэлтээрээ 2020 оны байдлаар нийт татваргүй барааны дэлгүүрүүдийн зах зээлд эхний 3-рт бичигдэж байгаа билээ.

За ингээд цааш нь үргэлжлүүлээд тайлангаа танилцуулъя.

2016 онд “Таван Богд Трейд” ХХК нь “Газар сүлжмэл” ХК-ийн 67 хувийн хувьцааг буюу хяналтын багцыг худалдан авч компанийн оноосон нэрийг “Жуулчин Дюти Фрий” ХК болгон өөрчилсөн бөгөөд мөн компанийн бүтэц, дотоод зохион байгуулалтыг өөрчлөн үйл ажиллагааг амжилттай явуулж байна аа.

Тус компанийн ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн хараат гишүүд “Таван Богд Трейд” ХХК-ийн захирал Ц.Баатарсайхан, Д.Хулан, Ц.Оргилболд, Ц.Оюунцэцэг, Ц.Цэцэнхүү, Ч.Ванчин-Эрдэнэ гэсэн 6 гишүүнтэй байна. Хараат бус гишүүд Я.Пүрвээ, Д.Байгальмаа, В.Хүрэлхад нар, Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Отгонбаяр би өөрөө, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ байна. ТУЗ-ийн гишүүдэд өөрчлөлт орсон зүйл байхгүй байна. 2020 оны 09 дүгээр сард хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлан Компанийн ТУЗ-ийн гишүүдийг 3 жилийн хугацаатай шинээр сонгосон болно.

Манай компани нь одоогийн байдлаар нийт 3-н чиглэлд /Галт тэрэг, Автозамын, Агаарын /-ны байрлалд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй ажиллаж байна.

1-р салбар УБТЗ Зорчигч Тээврийн Төв буюу Вокзалын 2 дугаар давхарт компанийн татваргүй барааны дэлгүүр байрладаг, гаалийн хяналтын доор үйл ажиллагаа явуулдаг. 2020 оны 3 дугаар сарын 10-аас Улсын онцгой комиссын Зорчигч Тээврийн хөдөлгөөнийг түр зогсоох 5 дугаар тогтоолын дагуу тухайн өдрөөс хойш үйл ажиллагаагаа явуулаагүй байна.

2-р салбар Алтанбулаг боомтын автозамын шалган нэвтрүүлэх төвийн 1 дүгээр давхарт байрладаг. Нийт талбай хэмжээ 46.7 м2 талбайтай, 2 складтай. 2020 оны 3 дугаар сарын 10-наас Улсын онцгой комиссын Зорчигч Тээврийн хөдөлгөөнийг түр зогсоох 5 дугаар тогтоолын дагуу тухайн өдрөөс хойш үйл ажиллагаагаа явуулаагүй байна

3-р салбар Нисэх салбар нь талбайн хэмжээний хувьд нисэх дотор байдаг дэлгүүрүүдийн дотор хамгийн томд тооцогддог. Хувьцаа эзэмшигч та нар мөн гадагшаа нисэхдээ өөрсдийн

дэлгүүрээр орж харсан байх гэж найдаж байна. Та бүхнийг бас өөрсдийн дэлгүүрээр үйлчлүүлээрэй гэж хүсэж байна.

2020 оны 3 дугаар сарын 10-наас Улсын онцгой комиссын Зорчигч Тээврийн хөдөлгөөнийг түр зогсоох 5 дугаар тогтоолын дагуу тухайн өдрөөс хойш зөвхөн зөвшөөрөгдсөн чартер нислэгийн үед /тусгай үүргийн нислэг/ хэсэгчлэн үйл ажиллагаагаа явуулж байна

Өөрөөр хэлбэл 2020 оны 03 сарын 11-ний өдрөөс манай компанийн бүтэн 1 жил 1 сарын хугацаанд цар тахлын болон хил нээгээгүй нь манай үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж компанийн орлого зогсонги байдалтай байна. Улс орон ийм хүнд байгааг харгалзан үзэж нийт ажилтнууддаа сул зогсолт зарлан сул зогсолтын үеийн олговор олгож байна. Хөшигтийн хөндийд шинээр олон улсын нисэх буудал баригдсан тэр дотор шинээр дэлгүүр нээх ажиллагаа Монгол Улс 49 хувь, Япон улс нь 51 хувийг нь эзэмшээд Японы тал менежментийг нь хариуцаад ажиллаж байгаа юм байна лээ. Шинэ нисэх онгоцны буудлын татваргүй барааны дэлгүүрийн тендер сонгон шалгаруулалтыг өнгөрсөн оны 2019 оны 11 дүгээр сард зарласан.

Дээрх сонгон шалгаруулалтад манай компани оролцсон, боловч биднийг 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдөр дуудаж уулзаад сонгон шалгаруулалттай холбоотой тайлбарыг авсан. Гэтэл 2 дугаар сарын 19-ний өдөр биднийг тус сонгон шалгаруулалтад тэнцээгүй гэсэн хариуг цахим хаягаар ирүүлснийг бид хүлээн зөвшөөрөөгүй. Ингээд бид Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан хэрэг хянан шийдвэрлэх шатандаа явж байна. Өнөөдрийн байдлаар ямар нэгэн шийдвэр гараагүй байна. Мөн бид хөл хориотой холбоотой өөрсдөө шүүхийн маргаанд оролцох боломж хомс байгаа тул Төв аймагт байрлах хуулийн фирмтэй өмгөөллийн үйлчилгээний гэрээ байгуулан ажиллаж байна.

За ингээд санхүүгийн тайланг танилцуулъя.

Компанийн цэвэр борлуулалт 762 сая, өмнөх оныхоос 79%-р буурсан, барааны борлуулалтын өртөг 410 сая, өмнөх оныхоос 79.9%-р буурсан үзүүлэлттэй байна. Өнгөрсөн онд 676 саяын цэвэр ашигтай ажиллаж байсан бол 2020 онд Тайлант хугацааны нийт 26,7 сая төгрөгийн цэвэр ашигтай буюу цэвэр ашгийн 96.1%-р бууралттай ажилласан байна.

2020 оны санхүүгийн тайланг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан жагсаалтад бүртгэлтэй “Эс Жи Ди Эм Аудит” ХХК-тай гэрээ байгуулан 2020 оны 12-р сарын 31-ны байдлаар санхүүгийн тайланд Хараат бус аудиторын дүгнэлт гаргуулсан болно. Дүгнэлтэд 2020 оны 12-р сарын 31-ний санхүүгийн тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад аудит хийлгэсэн. Ямар нэгэн зөрчилгүй үнэн зөв гэсэн хөндлөнгийн аудитын дүгнэлт гарсан.

Та бүхэн санхүүгийн тайлантай танилцаж болно.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Та бүхнээс өнгөрсөн оны буюу 2020 оны санхүүгийн тайлантай холбоотой асууж тодруулах зүйл байна уу.

Байхгүй гэв.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Хувьцаа эзэмшигч нараас 2020 оны санхүүгийн тайлантай холбоотой асууж тодруулах зүйл байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудлаа хэлэлцье. Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Отгонбаяр Компанийн 2021 оны санхүүгийн төлөвлөгөө, төсвийг танилцуулна.

Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Отгонбаяр: 2021 онд нийт Борлуулалтын төлөвлөгөөг 1,229,230,134 төгрөг байхаар төлөвлөсөн. 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 21,272,000 төгрөгийн борлуулалтай ажилласан байна. Тайлант үеийн ашиг алдагдал нь 15 сая төгрөгийн алдагдалтай гарсан байна. Маркетингийн зардал маань 199 сая, Ерөнхий удирдлагын зардал 97,5 сая төгрөг, тайлант хугацааны цэвэр ашиг 217 сая төгрөгийн төлөвлөгөөтэй байна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: 2021 оны санхүүгийн төлөвлөгөө, төсвөөс асууж тодруулах зүйл байна уу? хувьцаа эзэмшигч нараас.

Байхгүй гэв.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал маань ногдол ашиг тараах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах.

Компанийн ТУЗ нь 2021 оны 02-р сарын 10-ны өдөр хуралдаж ногдол ашиг тараах эсэх тухай тогтоол гарсан. Дээрх тогтоолоор 2020 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигч нарт ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн байна. Ногдол ашиг тараахгүй байх шалтгаан нь МУ-д COVID-19 цар тахлын нөхцөл байдал үүсэж МУ-ын Засгийн газраас улсын хилийг хаах шийдвэр гарч компанийн үйл ажиллагаа 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс бүрэн зогссонтой холбоотойгоор ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн байна. Ногдол ашиг тараах эсэх тогтоолтой холбоотой хувьцаа эзэмшигч нараас асууж тодруулах зүйл байна уу.

Байхгүй гэв.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё. Компанийн санхүүгийн болон үйл ажиллагаанд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулна.

ТУЗ-ийн дүгнэлтийг уншиж танилцуулав.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудлыг хэлэлцэж дууслаа. Хувьцаа эзэмшигч нараас компанийн үйл ажиллагаатай холбоотой болон өнөөдрийн хурлаар хэлэлцсэн асуудлаас асууж тодруулах зүйл байна уу?

Байхгүй гэв.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Хурлын дэгийн дагуу хэлэлцсэн асуудлын хүрээнд 2 асуудлаар санал хураалт явуулна. 1-р санал хураалт ТУЗ-ийн санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг батлах тухай санал хураалт, 2-р санал хураалт нь Компанийн 2021 оны санхүүгийн төлөвлөгөө төсвийг батлах санал хураалт явагдана.

Саналын хуудас болон санал хураалттай холбоотой асууж тодруулах зүйл байвал нээлттэй шүү.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Тооллогын комиссоос 2 саналын дүнгээ нэгтгэн та бүхэнд танилцуулахад бэлэн болсон байна.

Тооллогын комиссын дарга Т.Солонго: Нийт өнөөдрийн хуралд 2 хувьцаа эзэмшигч итгэмжлэгдсэн төлөвлөгөөгөөр дамжуулан хуралд оролцсон, 1 хувьцаа эзэмшигч урьдчилан санал өгч оролцсоноос 100 хувийн саналаар ТУЗ-ийн 2020 санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг батлахаар шийдвэрлэсэн байна. Саналын 2-р хуудас буюу компанийн 2021 оны санхүүгийн төлөвлөгөө, зардлын төсвийг батлах саналын хуудсыг 100% зөвшөөрч батлахаар шийдвэрлэсэн байна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ:

1. 2021 оны санхүүгийн төлөвлөгөө, зардлын төсвийг батлах
2. ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай тогтоолын төслүүдийг батлахаар 100 хувийн санал өгсний танилцуулав.

Хурлаар хэлэлцэх асуудлын хүрээнд оруулсан 2 асуудлаар хэлэлцсэн асуудлыг 100 хувь дэмжигдсэн учраас тогтоолын төслийг батлахаар шийдвэрлэсэн тул тогтоолыг төслийг танилцуулан баталлаа.

Ингээд өнөөдрийн хурал өндөрлөж байна хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Хурлыг хааж үг хэлнэ үү хэмээн хурлын дарга Ц.Отгонбаярыг урьж байна.

Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Отгонбаяр: “Жуулчин Дютри Фрий” ХК-ийн 2021 оны ХЭ хуралд хүрэлцэн ирж оролцсон та бүхэнд баярлалаа. Онцгой нөхцөл байдлаас шалтгаалан бидний шууд хийгддэг байсан ажил маань хийх боломжгүй хязгаарлагдмал байна. Тийм учраас ийм хүнд нөхцөл байдалтай байгаа ч компанийн зүгээс хууль дүрэм журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийе, тайлангаа танилцуулъя гэж зориг та бүхний оролцоотой амжилттай хурлаа хийж дуусаж байна.

Ингээд та бүхний ажилд амжилт хүсэн энэ хориг маань хурдан нээгдээсэй гэж ерөөл дэвшүүлье ээ.

Хурлын дарга:  Ц.Отгонбаяр

Тэмдэглэл хөтөлсөн:  Б.Бат-Эрдэнэ

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга



2021 оны 04 сарын 26-ны өдрийн 10 цаг 50 минутад дуусав.

1037693